



ПРЕМИУМ НЭКСУС ХК  
(MSE: CUMN)

### АШИГТ АЖИЛЛАГААНЫ МЭДЭГДЭЛ

Премиум Нэксус ХК (MSE: CUMN) нь хувьцааны үнэд нөлөөлж болзошгүй дотоод мэдээллийг албан бус сувгаар задрахаас урьдчилан сэргийлэх үүднээс, олон улсын жишгийн дагуу энэхүү мэдэгдлийг Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлж, өөрийн цахим хуудсанд байршуулж байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2024 оны аудитлагдаагүй санхүүгийн үзүүлэлт болон одоогийн мэдээлэлд үндэслэн Компанийн 2024 оны санхүүгийн үр дүнг урьдчилан мэдээлэх шийдвэр гаргалаа.

2024 оны аудитлагдаагүй тайлангаар Премиум Нэксус ХК-ийн цэвэр ашиг **₮28-30 тэрбум** байх төлөвтэй байгаа ба үүнээс гадна, Чингис Шар Айраг ХХК-ийг худалдан авсантай холбоотойгоор **₮19-23 тэрбум** төгрөгийн нэг удаагийн бизнесийн нэгдлийн олз бүртгэгдэж, нийт тайлант үеийн цэвэр ашиг **₮47-53 тэрбум** болох хүлээлттэй байна. Бизнесийн нэгдлийн бодит үнэ цэнийн үнэлгээнээс үүссэн олз нь компанийн үндсэн үйл ажиллагааны ашиг биш бөгөөд нэг удаагийн санхүүгийн үр дүн болно.

Энэхүү мэдэгдэл нь аудитлагдаагүй нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлт болон одоо байгаа мэдээлэлд тулгуурласан таамаглал бөгөөд хараат бус аудитын байгууллага болон бусад хяналтын байгууллагаар баталгаажаагүй болно. Компанийн санхүүгийн үзүүлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл 2024 оны жилийн эцсийн тайланд тусгагдах болохыг анхаарна уу

Г.Чинзориг  
Гүйцэтгэх захирлын орлогч  
Премиум Нэксус ХК